



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/124

Арвайхээр

Аян зохион байгуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын а, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, Засгийн газрын 2016 оны “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр батлах тухай” 233 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас “Хариуцлагатай хэрэглээ-Хэрэглэгчийн эрхийн жил” болгон зарласантай холбогдуулан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Олон улсын өдрийн хүрээнд “Аюулгүй, ухаалаг бараа, бүтээгдэхүүн” аяныг 2019 оны 3 дугаар сарын 5-15-ны өдрүүдэд зохион байгуулж, ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөний дагуу аяныг үр дүнтэй зохион байгуулж, тайлан мэдээг 3 дугаар сарын 20-ны дотор сум, байгууллагынхаа албан ёсны цахим хуудаст нийтэлж, иргэд олон нийтийг мэдээлэлээр хангаж ажиллахыг сум, байгууллагын дарга, эрхлэгч нарт, аймгийн хэмжээнд зохион байгуулсан ажлын тайланг нэгтгэн танилцуулж, холбогдох газарт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын орлогч, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах аймгийн орон тооны бус зөвлөлийн дарга (И.Доржсүрэн)-д тус тус үүрэг болгосугай.

3. Аяны арга хэмжээнд шаардагдах 700.000 (Долоон зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100280